

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ноён сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/49/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Даланзадгад хот
2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс аудит” ХХК

Захирал: Ш.Ичинхорлоо
Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	98.2	107.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,330.8	1350.2
	Нийт хөрөнгийн дүн	1,429.0	1,457.9
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,429.0	1,457.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,429.0	1,457.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	687.4	609.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	640.3	580.9
	Үйл ажиллагааны үр дүн	47.1	28.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	47.1	28.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	514.8	514.8
	Тайлант оны үр дүн	914.1	942.9
	Эцсийн үлдэгдэл	1,428.9	1,457.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	607.0	528.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	607.0	528.5
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	514.6	504.5
	Урсгал зардал	514.6	504.5

	Хөрөнгийн зардал	-	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	514.6	504.5
	Улсын төсвөөс санхүүжих	402.7	394.1
	Орон нутгийн төсвөөс	110.9	110.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1.0	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Ноён сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Суралцагчийн хөгжил, төлөвшилд анхааран, бүх талын оролцоог нэмэгдүүлж, сурлагын чанарт ахиц гарган, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 9 арга хэмжээ төлөвлөсөн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” МУЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Боловсрол, шинжлэх Ухааны Сайд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайд, Сангийн Сайдын хамтарсан тушаал 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дугаар А/35/А/10/9
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхийн нийтээр Ковид-19 өвчлөлтэй холбоотойгоор БШУЯ-ны сайдын тушаалын дагуу сургалтын үйл ажиллагааг 3, 9, 10, 11, 12 саруудад буюу 5 сар танхимаар болон цахимаар хосолсон хэлбэрээр явуулсан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Ноён сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Суралцагчийн хөгжил, төлөвшилд анхааран, бүх талын оролцоог нэмэгдүүлж, сурлагын чанарт ахиц гарган, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 106,440.1 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 88.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 103,813.4 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах 4 зөвлөмж өгсөн, 2,538.7 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн ба залруулагдаагүй 106,352.1 мянган төгрөгийн алдаа зөрчил, тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшинээс 102,695.2 мянган төгрөгөөр давсан хэдий ч санхүүгийн тайлагналд нөлөөлөлгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Өмнөговь аймгийн Ноён сумын Ерөнхий боловсролын сургууль	7	106,440.1	1	88.0	-	-	2	2,538.7	1	103,813.4